

“АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ЖУРАМ”

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмыг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт шинээр барих, их засвар, шинэчлэлт хийх инженерийн хийцтэй бүх төрлийн авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад мөрдөнө.

Хоёр. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох

2.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан хуулийн этгээд /цаашид Гүйцэтгэгч гэх/ нь авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлт гаргахдаа энэхүү журмын 4 дүгээр хавсралтын А хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлсэн тухайн авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник технологийн хяналт тавих эрх бүхий Зөвлөх /цаашид Зөвлөх гэх/-өөр хянуулан Захиалагчид хүргүүлнэ.

2.2 Захиалагч авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан баримт бичгийн бүрдэл шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, шийдвэрлэнэ. Дурдсан хугацаанд хүсэлтийг шийдвэрлээгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг Гүйцэтгэгчид албан бичгээр ажлын 3 хоногт багтаан хүргүүлнэ.

2.3. Барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг тухайн авто зам, замын байгууламж баригдаж дуусах хүртэлх гэрээнд заасан хугацаагаар олгоно. Барилгын ажил гэрээт хугацаанд дуусаагүйгээс гэрээний хугацаа сунгасан бол зөвшөөрлийн маягтад сунгасан тухай тэмдэглэнэ.

2.4. Зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд барилгын ажил эхлээгүй тохиолдолд тухайн зөвшөөрөл хүчингүй болсонд тооцогдоно. Энэ тохиолдолд Захиалагчид ажил эхлүүлэх хүсэлтийг дахин гаргаж шийдвэрлүүлнэ.

Гурав. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох

3.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил дараах шалтгаанаар 6 сараас дээш хугацаагаар зогссон бол ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл авна. Үүнд:

-Салбарын хяналт болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр ажлыг зогсоосон;

-Техник технологийн хяналтын Зөвлөхийн санал дүгнэлтэд үндэслэн Захиалагчийн шийдвэрээр ажлыг зогсоосон.

3.2 Дээрх үндэслэлээр барилгын ажил зогссон бол Гүйцэтгэгч энэхүү журмын 4 дүгээр хавсралтын Б хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлж, ажил зогсоосон шалтгаан, зөрчил дутагдлыг арилгасан тухай эрх бүхий байгууллагын дүгнэлтийн хамт ажил үргэлжлүүлэх хүсэлтийг Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч ирүүлсэн

баримт бичгийг нягталж, шаардлага хангасан бол ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Дөрөв. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах

4.1. Авто замын тухай хуулийн 28.1; 28.2-т заасан эрх бүхий байгууллага буюу Захиалагчийн зүгээс авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /цаашид “Ажлын хэсэг” гэх/-ийг томилно.

4.2. Гүйцэтгэгч авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах Ажлын хэсэг ажиллуулах хүсэлт гаргахдаа энэхүү журмын 4 дүгээр хавсралтын В хэсэгт заасан баримт бичиг, холбогдох материалыг бүрдүүлэн Зөвлөхөөр хянуулж, баталгаажуулан Захиалагчид хүргүүлнэ.

4.3. Захиалагч хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Ажлын хэсэг ажиллуулах эсэх шийдвэр гаргана. Захиалагч Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилохдоо авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран энэхүү журмын хоёрдугаар хавсралтыг удирдамж болгоно.

4.4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор ажиллана.

4.5. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах Ажлын хэсгийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэлийг хангуулах ажлыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, хяналтын Зөвлөх, Гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулна.

4.6. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хуралдаан зохион байгуулах, гишүүдийн ирц бүрдүүлэх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, акт (дүгнэлт)-ийн төсөл боловсруулж баталгаажуулах, техникийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан архивд хүлээлгэн өгөх ажлыг гүйцэтгэгч, зөвлөхтэй хамтран хариуцна.

4.7. Ажлын хэсэг томилсон шийдвэрийн дагуу газар дээр нь ажиллахаар товлосон өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө ажиллах газар, хугацаа, тухайн авто зам, замын байгууламжтай холбоотой ерөнхий мэдээллийг Ажлын хэсгийн нийт гишүүдэд хүргүүлсэн байна.

4.8. Ажлын хэсгийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд энэ тухай Ажлын хэсгийн дарга болон нарийн бичгийн даргад газар дээр нь ажиллахаас 1-ээс доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэн байна. Тухайн гишүүнийг томилсон байгууллагаас орлон ажиллах албан тушаалтны шийдвэрийг Ажлын хэсэгт ирүүлнэ.

4.9. Ажлын хэсэг болон ажиллах нөхцөл бололцоо хангаагүй дахин ажилласан тохиолдолд зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

4.10. Хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдсэн болон ашиглалтын шаардлага, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх талаар чанар байдлын дүгнэлт гаргуулна. Үүнд:

4.10.1. 0-5 км хүртэлх авто зам, замын байгууламжийн ажилд Зөвлөхийн дүгнэлт гаргуулах;

4.10.2. 5-аас дээш километр авто замын барилга, засвар ажилд мэргэжлийн байгууллагаар чанар байдлын дүгнэлт гаргуулах.

4.11. Шаардлагатай тохиолдолд хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр 50 дээш километр авто замын барилга, их засвар шинэчлэлтийн ажилд замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээ хийлгэх.

Тав. Ажлын хэсгийн эрх, үүрэг

5.1. Ажлын хэсэг нь Авто замын тухай хууль болон бусад хууль, тогтоомж, авто зам, замын байгууламжийн зураг төсөл, стандарт, техникийн баримт бичигт заасан шаардлага, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах үүрэгтэй.

5.2. Ажлын хэсэг нийт гишүүдийн 90-ээс дээш хувийн ирц бүрдсэнээр ажиллана. Ажлын хэсгийн гишүүн **ажлын хэсэгт ажиллах** боломжгүй бол тухайн гишүүнийг томилсон байгууллагаас орлон ажиллуулах **албан тушаалтныг томилуулна.**

5.3. Ажлын хэсгийн нийт гишүүдийн санал дүгнэлтийг үндэслэн, дийлэнх олонхийн саналаар эцсийн шийдвэр гаргана. Энэхүү шийдвэр нь “Авто замын тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

5.4. Ажлын хэсгийн гишүүд мэргэжлийн чиглэл, ажлын чиг үүргийн дагуу ажиллаж, хариуцсан асуудал тус бүрээр санал дүгнэлтээ танилцуулна. Үүнд:

5.4.1. Авто зам, замын байгууламжийн батлагдсан зураг төсөл техникийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх, гүйцэтгэлийн чанар, ашиглалтын болон хөдөлгөөний аюулгүй байдал хангасан эсэх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар нарийвчлан шалгах, дүгнэлт гаргах;

5.4.2. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичгийн бүрдүүлэлт, баталгаажуулалт хийсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх хүрээний шаардлага хангасан байдлыг шалгах, нягтлах;

5.4.3. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын хүрээнд хийгдсэн бусад байгууламж, төлбөр авах цэгийн барилга, суурилагдсан тоног төхөөрөмж, инженерийн нэмэлт шугам сүлжээний ажилд сорилт туршилт, тохируулга, зүгшрүүлэлт зэргийг стандартын шаардлага хангасан эсэх зэрэг ажил, үйлчилгээ явуулах, ашиглахад бэлэн эсэхийг шалгаж, дүгнэх;

5.4.4. Зохих журмын дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх үнэлгээг ашиглалтад оруулах Ажлын хэсгийн акт, дүгнэлтэд тусгах;

5.5. Авто замын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн заалтыг ноцтойгоор зөрчсөн тохиолдолд Гүйцэтгэгч, зөвлөх, зураг зохиогч байгууллагад хариуцлага тооцох, тусгай зөвшөөрлийн эрх түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

5.6. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлыг дутуу буюу хууль тогтоомж, стандарт, норм, норматив, дүрэм, зураг төсөл, техникийн нөхцөл шаардлагыг зөрчиж чанаргүй хийсэн, барилгын ажлын явцад Захиалагч болон Зөвлөх, Салбарын хяналтын байгууллагуудаас тавьсан шаардлага, дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд ашиглалтад оруулахаас татгалзана.

5.7. Авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад оруулах, шийдвэр гаргаж болно.

5.8. Ажлын хэсгийн гишүүд зураг төсөл, техникийн шаардлагын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах шаардлагатай үүрэг чиглэл өгч, гүйцэтгэлийн биелэлтийг ажлын хэсэгт танилцуулж нэгдсэн зөвшилцөлд хүрсэн тохиолдолд энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулснаар Ажлын хэсгийн шийдвэр хүчин төгөлдөр болно.

5.9. Ажлын хэсгийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хурлын тэмдэглэлд тусгасны дагуу Гүйцэтгэгч заасан хугацаанд чанартай гүйцэтгэж, биелэлтийг тайлагнах бөгөөд гүйцэтгэлийн чанарт Зөвлөх болон зам хариуцагч байгууллага хяналт тавьж ажиллана.

5.10. Ажлын хэсгийн акт баталгаажаагүй, архивын нэгжийг шаардлагын дагуу бүрдүүлж архивт хүлээлгэн өгөөгүй тохиолдолд Гүйцэтгэгч болон Зөвлөхийн эцсийн шатны санхүүжилт олгохыг хориглоно.

Зургаа. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлынтехник технологийн хяналтын Зөвлөхийн эрх, үүрэг

6.1. Зөвлөх нь авто зам, замын байгууламжийн барилгын ажил бүрэн дууссан тухай мэдэгдэл болон авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах Ажлын хэсэг ажиллуулах хүсэлтийг хянаж баталгаажуулан Захиалагчид хүргүүлнэ.

6.2. Барилгын ажлын үе шатны техник технологийн зөвлөх болон Захиалагч, хяналтын байгууллагаас тавьсан албан шаардлага, Ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Гүйцэтгэгчээр гаргуулж, хянаж баталгаажуулан Ажлын хэсэгт хүргүүлнэ.

6.3. Зөвлөх нь тухайн авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаанд тухайн объектын чанар байдалд гэрээнд заасны дагуу үзлэг хийж, дүгнэлт гаргаж, Захиалагчид ирүүлнэ.

6.4. Гүйцэтгэлийн чанар, технологийн алдаанаас үүссэн эвдрэл гэмтлийг Гүйцэтгэгч засварлах үйл ажиллагаанд хяналт тавьж, чанарыг баталгаажуулна.

6.5. Авто зам, замын байгууламжийн ажил дутуу, чанаргүй хийгдсэнээс Ажлын хэсэг дахин ажиллуулах тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг хариуцна.

6.6. Ашиглалтад орсон тухайн авто зам, замын байгууламжийн гүйцэтгэлийн зураг, паспортыг Ажлын хэсэг газар дээр нь ажиллахаас өмнө Гүйцэтгэгчээр гаргуулж, баталгаажуулсан байна.

Долоо. Гүйцэтгэгчийн үүрэг

7.1 Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, стандарт, норм норматив, техникийн шаардлагын дагуу чанартай гүйцэтгэж, Ажлын хэсгийн дүгнэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгана.

7.2. Авто замын тухай хуулиар авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаа 3 жил байхаар заасны дагуу Гүйцэтгэгч түүний чанарыг хариуцах, барилга, засвары ажлын технологийн алдаанаас үүдэн гарсан эвдрэл, гэмтэл, засварын ажилд график төлөвлөгөө боловсруулж, захиалагчаар батлуулан, өөрийн хөрөнгөөр тухай бүр засварлаж, биелэлтийг зөвлөхөөр хянуулж баталгаажуулан Захиалагчид ирүүлнэ.

7.3. Ашиглалтад орсон тухайн барилга байгууламжийн гүйцэтгэлийн зураг, баримт бичгийн бүрдлийг бүрэн хангаж, батлагдсан маягтын дагуу замын паспорт, гүүр, хоолойн картыг үнэн зөв хөтөлж, цаасан болон цахим хэлбэрээр авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч зам хариуцагч байгууллагын архивт хүлээлгэн өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

Найм. Чанарын баталгаат хугацаа, барьцаа хөрөнгө чөлөөлөх

8.1. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш чанарын баталгаат хугацаанд тогтмол үзлэг хийж технологийн эвдрэл гарсан тохиолдолд Гүйцэтгэгч шуурхай засварлан, Зөвлөхөөр хянуулж тайланг Захиалагчид ирүүлнэ.

8.2. Баталгаат засварын хугацааг ашиглалтад оруулах Ажлын хэсгийн акт, хурлын тэмдэглэл баталгаажсан өдрөөс эхлэн тооцно.

8.3. Авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад оруулсан тохиолдолд тухайн хэсэгт чанарын баталгаат хугацааг энэхүү журмын 8.2 дахь заалтын дагуу тооцно.

8.4. Чанарын баталгаат хугацаа дууссаны дараа дор дурдсан баримт бичгийг үндэслэн, Захиалагчийн албан ёсны зөвшөөрлөөр барьцаа хөрөнгийг чөлөөлнө. Үүнд:

8.4.1. Баталгаат засварын хугацаанд хийгдсэн ажлын тайлан;

8.4.2. Техник технологийн хяналтын Зөвлөхийн дүгнэлт;

8.4.3. Зам хариуцагч байгууллагын тодорхойлолт;

8.5. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах Ажлын хэсгийн акт баталгаажсанаар гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.

8.6. Ажлын хэсгийн акт, хурлын тэмдэглэл баталгаажснаас хойш 1 жилийн дотор технологийн эвдрэл, гэмтэл гараагүй тохиолдолд Зөвлөх болон Гүйцэтгэгчийн барьцаа хөрөнгийн 50 хувийг чөлөөлнө. Гүйцэтгэгч гэрээнд заасан чанарын баталгаат хугацаа дуусахад барьцаа хөрөнгийн үлдэгдлийг бүрэн чөлөөлнө.

Ес. Хүлээх хариуцлага

9.1. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулах үйл ажиллагааны явцад барилгын ажлын талаар худал мэдээлэл өгсөн талууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

9.2. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах үед гэрээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн архивын материалын бүрдэлтэд хяналт тавьж

ажиллах бөгөөд бүрдэл дутуу материал архивт хүлээлгэн өгсөн тохиолдолд тухайн мэргэжилтэн болон архивын ажилтанд хариуцлага тооцно.

9.3. Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах Ажлын хэсгийн гишүүд хууль зөрчиж, алдаатай шийдвэр, дүгнэлтийг санаатай болон болгоомжгүйгээр гаргасан нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

oOo

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил
эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах
журам”-ын нэгдүгээр хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар...

20 ... оны ... сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

1.Авто зам, замын байгууламж түүний туслах барилгуудын мэдээлэл:

Авто зам, замын байгууламж, объектын нэр:.....

Хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц

Хаяг: аймаг /нийслэл/,.....сум /дүүрэг/,

.....баг /хороо/,.....гудамж /хороолол/

Зургийн шифр..... Магадлалын дугаар

Зөвшөөрөл олгосон үе шатны ажлын нэр:.....

Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:.....

2.Газар олгосон шийдвэрийн мэдээлэл:

Газар олгосон шийдвэрийн (захирамж): 20... онысарын өдрийн..... дугаар

Байршил:..... аймаг /нийслэл/,.....сум /дүүрэг/,

.....баг /хороо/,.....гудамж /хороолол/

3.Гүйцэтгэгч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:.....

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:.....

Хаяг: аймаг /нийслэл/,.....сум /дүүрэг/,

.....баг /хороо/,.....гудамж /хороолол/

Холбоо барих:..... цахим хаяг, утасны дугаар

4.Захиалагч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:.....

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Хаяг: аймаг /нийслэл/,.....сум /дүүрэг/,

.....баг /хороо/,.....гудамж /хороолол/

Холбоо барих:..... цахим хаяг, утасны дугаар

5.Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг эрхлэгч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:.....

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:.....

Хаяг: аймаг /нийслэл/,.....сум /дүүрэг/,

.....баг /хороо/,гудамж /хороолол/

Холбоо барих:..... цахим хаяг, утасны дугаар

6.Зураг зохиогч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:.....

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:.....

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж

Холбоо барих:..... цахим хаяг, утасны дугаар

7.Онцгойлон заах нөхцөл:.....

8.Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд:.....

9.Зөвшөөрөл олгогч байгууллагын тусгай тэмдэглэл:

.....

10.Зөвшөөрөл олгосон албан тушаалтны мэдээлэл:

..... байгууллагын нэр, албан тушаал,
..... овог нэр, гарын үсэг,
(тамга, тэмдэг)

ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАЛТ

..... оны ... -р сарын ... –ны өдөр

1.Зөвшөөрлийн хугацааг сунгах шалтгаан, үндэслэл:

2.Барилгын ажлын явцын мэдээлэл:

Гүйцэтгэсэн ажлын үе шат, нэр, төрөл, хэмжээ

3.Зөвшөөрлийг сунгах хугацаа:

4.Онцгойлон заах нөхцөл:

5.Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд:.....

6.Зөвшөөрөл олгогч байгууллагын тусгай тэмдэглэл:

7.Зөвшөөрөл сунгасан албан тушаалтны мэдээлэл:

..... байгууллагын нэр, албан тушаал,

..... овог нэр, гарын үсэг

(тамга, тэмдэг)

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил
эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын
хоёрдугаар хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

| № | Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал | Ашиглалтад авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн | | |
|---|---|---|---|---|
| | | Дарга | Нарийн бичгийн дарга | Гишүүд |
| 1 | 1.Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламж 2.Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж | Салбарын төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан тушаалтан | Салбарын төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтэн | 1.Захиалагчийн төлөөлөл 2.Зураг зохиогч байгууллагын төлөөлөл 3.Техник технологийн хяналтын зөвлөхийн төлөөлөл 4.Авто замын бүртгэл мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн 5.Зам хариуцагч байгууллагын төлөөлөл 6.Байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл 7.Замын цагдаагийн албаны төлөөлөл 8.Салбарын хяналт хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл 9.Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл 10.Орон нутгийн засаг захиргааны байгууллагын авто замын асуудал хариуцсан ажилтан /Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран бусад байгууллагаас нэмж төлөөлөл томилж болно./ |
| № | Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал | Ашиглалтад оруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн | | |
| | | Дарга | Нарийн бичгийн дарга | Гишүүд |
| 2 | Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын харьяа | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын | 1.Захиалагчийн төлөөлөл 2.Зураг зохиогч байгууллагын төлөөлөл |

| | | | | |
|---|--|---|--|--|
| | | авто замын асуудал эрхэлсэн агентлагийн холбогдох газар, хэлтсийн дарга | харьяа авто замын асуудал эрхэлсэн агентлагийн мэргэжилтэн | 3.Техник технологийн хяналтын зөвлөхийн төлөөлөл 4.Орон нутгийн захиргааны байгууллагын авто замын бүртгэл мэдээллийн сан хариуцсан ажилтан 5.Зам хариуцагч байгууллагын төлөөлөл 6.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл 7.Аймаг, нийслэлийн замын цагдаагийн албаны төлөөлөл 8.Аймаг, нийслэлийн салбарын хяналт хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл (эрчим хүч, харилцаа холбоо, барилгын техникийн хяналтын байцаагч тухайн чиглэлийн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн тохиолдолд) 9.Онцгой байдлын газрын төлөөлөл (шаардлагатай тохиолдолд) 10.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл /Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран бусад байгууллагаас нэмж төлөөлөл томилж болно./ |
| № | Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал | Ашиглалтад оруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн | | |
| | | Дарга | Нарийн бичгийн дарга | Гишүүд |
| 3 | Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам, замын байгууламж | Захиалагч байгууллага | Захиалагч байгууллага | 1.Захиалагчийн төлөөлөл 2.Зураг зохиогч байгууллагын төлөөлөл 3.Техник технологийн хяналтын зөвлөхийн төлөөлөл 4.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл 5.Аймаг, нийслэлийн замын цагдаагийн албаны төлөөлөл 6.Аймаг, нийслэлийн салбарын хяналт |

| | | | | |
|--|--|--|--|--|
| | | | | <p>хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл (эрчим хүч, харилцаа холбоо, барилгын техникийн хяналтын байцаагч тухайн чиглэлийн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн тохиолдолд) /Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран бусад байгууллагаас нэмж төлөөлөл томилж болно./</p> |
|--|--|--|--|--|

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх,
үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын
гуравдугаар хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АКТ

Дугаар...

20 ... оны ... сарын ... -ны өдөр
хот

Улаанбаатар

НЭГ. Ерөнхий мэдээлэл

1.1.Авто зам, замын байгууламж, объектын нэр:.....

Хучин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц.....

Зургийн шифр..... Магадлалын дугаар

Хаяг:аймаг /нийслэл/,.....сум /дүүрэг/,

.....баг /хороо/,.....гудамж /хороолол/

1.2.Ерөнхий гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг:.....

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

1.3.Туслан гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг:.....

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

1.4.Зураг зохиогч байгууллагын нэр:

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

1.5.Захиалагч байгууллагын нэр, хаяг:.....

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

1.6.Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч байгууллагын нэр, хаяг:

.....

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

1.7.

шийдвэрээр зохион байгуулсан хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг нь уг барилга

байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай байгууллагын

20 ... оны ... сарын ... -ны өдрийндугаар мэдэгдлийн дагуу 20... оны ... сарын ... -ны

өдрөөс ...-ны өдрүүдэд шинээр барьсан /их засвар, өргөтгөл/ шинэчлэлтийн ажлын чанар,

холбогдох акт, баримтуудтай танилцаж, газар дээр нь ажиллаж, үзлэг шалгалт хийв.

1.8.Энэхүү авто зам, замын байгууламжийг

..... шифртэй зураг төслөөр оны сараас барьж эхэлсэн бөгөөд..... оны..... сарын

..... -ны өдөр барьж дуусгасан байна.

ХОЁР. Ажлын хэсгийн шийдвэр

Энэхүү авто зам, замын байгууламжийн зураг төсөл, холбогдох,

баримт бичиг, ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр ашиглалтад

оруулах Ажлын хэсгээс ШИЙДВЭРЛЭСЭН нь:

2.1.Энэхүү авто зам, замын байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж

.....

зориулалтаар ашиглахад гэж үзээд захиалагч байгууллага болох

..... , хариуцагч (ашиглагч) байгууллага болох мэдэлд 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс ашиглалтад оруулахыг зөвшөөрөв.

2.2. Уг авто зам, замын байгууламжийн үндсэн хөрөнгийг төгрөгөөр үнэлэв.

2.3. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан Ажлын хэсгээс даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

1. “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын 4 дүгээр хавсралтын В хэсэгт заасан баримт бичгийн бүрдлийг хангаж, техник, технологийн хяналтын зөвлөх байгууллагаар хянуулан архивд эх хувийг үлдсэн хувийг тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч, зам хариуцагч байгууллагад ... хоногийн дотор хүлээлгэн өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг хийх,

2. Авто замын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэгч, техник, технологийн хяналтын зөвлөх байгууллага авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш чанарын баталгааны 3 жилийн хугацаанд тухайн замд илэрсэн барилгын ажлын чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтлийг бүрэн хариуцах.

Зам хариуцагч (ашиглагч) байгууллагад:

1. Авто замын тухай хуулийн 27.3-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн паспорт, картыг хянаж, хүлээн авч, бүртгэл мэдээллийн санд баяжилт хийж, холбогдох мэдээллийг жил бүрийн тогтоосон хугацаанд авто зам эзэмшигчид хүргүүлж байх;

2. Авто замын тухай хуулийн 23.3.-т заасны дагуу чанарын баталгаат хугацаа дууссанаас хойш авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, арчлалт, засварын ажлыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

3. Ажлын хэсгийн акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал, барилга байгууламжийн баримт бичгийн , жагсаалтыг хавсаргав.

ГУРАВ. Актын баталгаажуулалт

.....
(Тухайн авто зам, замын байгууламжийн нэр, байршил, хүчин чадал)-г ашиглалтад оруулах акт гаргасан:

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Ажлын хэсгийн дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Тайлбар: Энэхүү хуудсанд Ажлын хэсэгт ажилласан гишүүдийн нэр багтаагүй тохиолдолд дараагийн хуудсанд үргэлжлүүлэн бичихдээ дээр нь тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.

Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-ын дөрөвдүгээр хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

| № | Бүрдүүлэх баримт бичиг |
|---|--|
| <u>А. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичиг</u> | |
| 1. | Гүйцэтгэгч байгууллагын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг |
| 2. | Гүйцэтгэгч байгууллагын улсын бүртгэлийн болон авто зам, замын байгууламжийн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар |
| 3. | Инженер техникийн ажилтан болон машин, механизм, тоног төхөөрөмжийн жагсаалт /Тендерийн баримт бичигт заасан/ |
| 4. | Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын гэрээ (туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ) |
| 5. | Улаан шугам хүлээлцсэн акт |
| 3. | Магадлал хийгдсэн тухайн авто зам, замын байгууламжийн иж бүрэн зураг төсөл, Экспертизийн дүгнэлт |
| 4. | Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд захиалагчийн техник, технологийн хяналт гүйцэтгэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ |
| 5. | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс газар олгосон шийдвэр, техникийн нөхцөлүүд |
| 6. | Байгаль орчинд нөлөөлөх ерөнхий байдлын үнэлгээ, шаардлагатай бол байгаль орчин нөлөөлөх байдлыг албажуулсан нарийвчилсан үнэлгээ / зураг төслийн шатанд хийсэн бол/ |
| 7. | Археологи, палеонтологийн тандалт, судалгааны тайлан / зураг төслийн шатанд хийсэн бол/ |
| <u>Б. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичиг</u> | |
| 1. | Ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн Гүйцэтгэгчийн албан хүсэлт |
| 2. | Ажил зогсоох шийдвэр гаргасан холбогдох эрх бүхий байгууллагын ажил үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр, дүгнэлт |
| 3. | Зөрчил арилсан тухай баримт, хийсэн ажлын тайлан |
| <u>В. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулахад бүрдүүлэх, архивт хүлээлгэн өгөх баримт бичиг</u> | |
| 1. | Захиалагчтай байгуулсан гэрээ /эх хувь/, нэмэлт гэрээ |
| 2. | Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл |
| 3. | "Авто замын тухай" хуулийн 4.1.18.-д заасан зураг төслийн иж бүрдэл /эх хувь/ |

| | |
|-----|---|
| 4. | Улаан шугам хүлээлцсэн акт |
| 5. | Ашиглалтад оруулах Ажлын хэсэг ажиллуулах хүсэлт гаргасан албан бичиг, Ажлын хэсэг байгуулсан тушаал, хурлын тэмдэглэл, баталгаажсан акт, гишүүдийн саналын хуудас |
| 6. | Гэрээ дүгнэсэн акт гарсан тохиолдолд /эх хувь/ |
| 7. | Санхүүжилтийн гүйцэтгэл (тооцоо нийлсэн акт) |
| 8. | Гүйцэтгэлийн зураг |
| 9. | Авто зам, замын байгууламжийн зурвас газрын кадастрын зураг |
| 10. | Археологи, палеонтологийн авран хамгаалах ажлын тайлан /эх хувь/ |
| 11. | Геодезийн хэмжилтийн материал |
| 12. | Лабораторийн шинжилгээний дүгнэлтүүд |
| 13. | Засаг даргын газар олгосон захирамж, карьеруудыг нөхөн сэргээсэн акт /байгаль орчны улсын байцаагчийн гарын үсэгтэй/ |
| 14. | Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан /эх хувь/ |
| 15. | Замын бүртгэл мэдээллийн паспорт, гүүр, хоолойн карт /цаасан болон цахим хэлбэрээр/ 4% |
| 16. | Зөвлөх багийн эхлэлийн, явцын, эцсийн шатны тайлан, шаардлага, дүгнэлт, түүний биелэлт, Голлон ажилласан замын инженер, техникийн ажилтнуудын тушаал шийдвэр, анкет, Зөвшөөрөл авах хүсэлтүүд, Гэрэл зургийн цомог, Ирсэн болон явуулсан албан бичиг, хурлын тэмдэглэлүүд, талбайн уулзалтын тэмдэглэл /он цагийн дарааллаар/ |
| 17. | Тухайн барилга, байгууламжид чанар байдлын дүгнэлт гаргах судалгаа хийгдсэн тохиолдолд дүгнэлт /Журмын 5.10.1, 5.10.2 дахь заалт/ (замын тэгш байдлын үзүүлэлт, хучилтын бат бэх, гадаргуугийн гулсалтын эсэргүүцэл, гадаргуугийн дугуй мөрний хotoйлт, гадаргуугийн барзгаржилт, далан суурийн даац, хурдны хангалт, хучилтын геометр хэмжээсүүд г.м) |

оОо

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”- д өөрчлөлт оруулж байгаа тул төрийн захиргааны байгууллагууд болон орон нутаг, аж ахуйн нэгж байгууллагууд, инженер технкийн ажилтнууд, иргэд идэвхтэй оролцож санал аа ирүүлнэ үү.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11, Засгийн газрын байр 13, Зам, тээврийн хөгжлийн яам
106 тоот, Утас-51263190, факс- 11312315, мэйл: batjargalts@mrttd.gov.mn

